



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 751

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 3 0 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168, Засгийн газрын 2022 оны 417 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээлэл технологийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 381,700,000.00 (гурван зуун наян нэгэн сая долоон зуун мянга) төгрөгийн балансын үнэ, 12,723,333.33 (арван хоёр сая долоон зуун хорин гурван мянга гурван зуун гучин гурван төгрөг гучин гурван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Цагдаагийн ерөнхий газар болон Хил хамгаалах ерөнхий газарт балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран нар болон тогтоолд заасан байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулж, үнийг шинэчлэн тогтоож, данс бүртгэлд тусгах ажлыг зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132003087

31-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 16 дугаар сарын 16 өдрийн
751 дугаар тогтоолын хавсралт

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДЭРГЭДЭХ МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ТӨВИЙН ҮНДСЭН ХӨРӨНГИЙН
ДАНСАНД БҮРТГЭЛТЭЙ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ

Д/д	Хөрөнгийн нэр	Тоо хэмжээ (ширхэг)	Ашиглалтад орсон он	Нэгжийн үнэ (төгрөг)	Балансын үнэ /төгрөг/	Хуримтлагдсэн элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Хөрөнгө хүлээн авах байгууллагын нэр
1	Сансрын холбооны "Старлинк" интернетийн төхөөрөмж /Starlink, Kickstand, Gen2 Router, Starlink cable 15m, AC cable 1.5m, Power supple 1.5m, ethernet adapter/	170	2024.10.07	1,735,000.00	294,950,000.00	9,831,666.66	285,118,333.34	Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Цагдаагийн ерөнхий газар
2	Сансрын холбооны "Старлинк" интернетийн төхөөрөмж /Starlink, Kickstand, Gen2 Router, Starlink cable 15m, AC cable 1.5m, Power supple 1.5m, ethernet adapter/	50	2024.10.07	1,735,000.00	86,750,000.00	2,891,666.67	83,858,333.33	Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Хил хамгаалах ерөнхий газар
Нийт дүн		220			381,700,000.00 (гурван зуун наян нэгэн сая долоон зуун мянга)	12,723,333.33 (арван хоёр сая долоон зуун хорин гурван мянга гурван зуун гучин гурван төгрөг гурван)	368,976,666.67 (гурван зуун жаран найман сая есөн зуун далан зургаан мянга зургаан зуун жаран зургаан төгрөг жаран)	